**ДУНДГОВЬ АЙМГИЙН**
**ЗАСАГ ДАРГА**
С.Буяннэмэхийн өргөн чөлөө 2-211, Нутгийн удирдлагын ордон, 7-р баг. Сайнцагаан сум, Дундговь аймаг 48090
Утас/факс: 70592353 Цахим шуудан: info@dundgovi.gov.mn
Цахим хуудас: www.dundgovi.gov.mn

2023. 11. 29 № 01/1547

танай ______ -ны № ______ -т

БАЙГАЛЬ ОРЧИН, АЯЛАЛ
ЖУУЛЧЛАЛЫН САЙД
Б.БАТ-ЭРДЭНЭ ТАНАА

Монгол Улсын Засгийн газрын зарим чиг үүргийг орон нутагт төлөөлөн 2023 онд хэрэгжүүлэх Байгаль орчин, аялал жуулчлалын салбарт хамтран ажиллах гэрээний хэрэгжилтийг жилийн эцсийн байдлаар гарган Засгийн газрын 2020 оны 206 дугаар тогтоолын дагуу Засаг даргын Тамгын газрын Хяналт-шинжилгээ, үнэлгээний хэлтэс дүгнэснийг хянан, 2024 онд байгуулах гэрээний саналын хамт хүргүүлэв.

Хавсралт 47 хуудастай.

Ц.МӨНХБАТ

4823141033

# МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ЗАРИМ ЧИГ ҮҮРГИЙГ ОРОН НУТАГТ ТӨЛӨӨЛӨН 2023 ОНД ХЭРЭГЖҮҮЛЭХ ГЭРЭЭНИЙ ХҮРЭЭНД БАЙГАЛЬ ОРЧИН, АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН САЛБАРТ ХАМТРАН АЖИЛЛАХ 23-10 ТООТ ГЭРЭЭНИЙ БИЕЛЭЛТЭД ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭ ХИЙСЭН АЖЛЫН ТАЙЛАН

2023 оны 11 сарын 29 Мандалговь хот

## НЭГ. ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ ЗОРИЛГО

Байгаль орчин аялал жуулчлалын сайд, аймгийн Засаг даргатай байгуулсан хамтран ажиллах гэрээний хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж, үйл ажиллагааны гүйцэтгэлийн үр дүнг хянах, үнэлэх, дүгнэлт зөвлөмж гаргах, үйл ажиллагааны төлөвлөлт, хэрэгжилт, тайлагналтыг сайжруулж, цаашид гарах үр дүн, үр нөлөөг нэмэгдүүлэхэд оршино.

## ХОЁР.ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ ҮНДЭСЛЭЛ, АРГА ЗҮЙ

Байгаль орчин аялал жуулчлалын сайдтай байгуулсан аймгийн Засаг даргын хамтран ажиллах гэрээний 2023 оны жилийн эцсийн хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээг Засгийн газрын 2020 оны 206 дугаар тогтоолоор баталсан “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт болон захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам”-ын 6.2-т заасан арга зүйгээр Хөгжлийн бодлого, төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтсээс ирүүлсэн тайланд үндэслэн хяналт-шинжилгээ, үнэлгээ хийлээ.

Байгаль орчин аялал жуулчлалын сайдтай аймгийн Засаг даргын байгуулсан хамтран ажиллах гэрээний 2023 оны эхний хагас жилийн хэрэгжилтийн явцад хяналт-шинжилгээ, үнэлгээг хийж хэрэгжилт удаашралтай арга хэмжээний жагсаалтыг гарган холбогдох хэлтэст хүргүүлэн цаашид анхаарах асуудал дээр зөвлөмж өгч ажилласан.

## ГУРАВ.ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ ҮР ДҮН

Байгаль орчин, аялал жуулчлалын салбарт 2023 онд хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг 9 зорилтын хүрээнд 46 ажил тусган хэрэгжүүлэхээр төлөвлөсөн. Эхний хагас жилийн хэрэгжилтэд явцын хяналт шинжилгээ хийхэд 70.3 хувьтай байсан ба жилийн эцсийн байдлаар 96.7 хувьтай хэрэгжүүлсэн байна. 2023 оны улсын төсвөөр хэрэгжүүлэхээр 8 ажлын саналыг хүргүүлсэн боловч, төсөв батлагдаагүй. Үүнээс 3 арга хэмжээг орон нутаг, хувийн хэвшлийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэн ажилласан бөгөөд 5 арга хэмжээг улсын төсвийн хөрөнгө оруулалт шийдвэрлэгдээгүй учир хэрэгжээгүй байна.

Нийт 46 арга хэмжээ хэрэгжүүлэхээс 37 арга хэмжээ 100 хувь, 80 хувь - 1, 55.8 хувь -1, 30 хувь-1 хэрэгжсэн байна. Гэрээгээр хүлээсэн арга хэмжээг

хэрэгжүүлэхийн тулд улсын төсвийн 86.0 сая.төг, орон нутгийн төсвийн 267.9 сая.төг, хувийн хэвшлийн 366.7 сая.төг, байгууллагын төсвийн 7.1 сая.төг, төсөл хөтөлбөрөөс 218.0 сая төгрөг, нийт 945.7 сая төгрөгийг дээрх арга хэмжээнүүдэд зарцуулсан байна.

**Гэрээний хэрэгжилтийг жилийн эцсийн байдлаар зорилт тус бүрээр харуулбал:**

<table>
<tr><th>№</th><th>Зорилтын нэр</th><th colspan="2">Арга хэмжээний тоо</th><th>Хэрэгжилтийн хувь</th></tr>
<tr><td>1</td><td>Байгаль орчны холбогдох хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангах</td><td colspan="2">8</td><td>94.5</td></tr>
<tr><td>2</td><td>Ногоон хөгжлийн бодлогын хэрэгжилтийг хангах талаар</td><td colspan="2">2</td><td>100</td></tr>
<tr><td>3</td><td>Хүрээлэн буй орчин байгалийн нөөцийг хамгаалах</td><td colspan="2">9</td><td>100</td></tr>
<tr><td>4</td><td>Усны нөөцийг зүй зохистой ашиглах, хамгаалах</td><td colspan="2">5</td><td>96</td></tr>
<tr><td>5</td><td>Тусгай хамгаалалттай газар нутгийг хамгаалах</td><td colspan="2">4</td><td>82.5</td></tr>
<tr><td>6</td><td>Ойн нөөцийг хамгаалах, “Тэрбум мод” хөдөлгөөнийг өрнүүлж, зорилтын хэрэгжилтийг хангах</td><td colspan="2">5</td><td>100</td></tr>
<tr><td>7</td><td>Аялал жуулчлалыг хөгжүүлэх талаар</td><td colspan="2">4</td><td>100</td></tr>
<tr><td>8</td><td>Уур амьсгалын өөрчлөлтийг сааруулах, дасан зохицох үйл ажиллагаа</td><td colspan="2">1</td><td>100</td></tr>
<tr><td rowspan="2">9</td><td rowspan="2">Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар гүйцэтгүүлэх ажлууд</td><td rowspan="2">8</td><td>5</td><td>-</td></tr>
<tr><td>3</td><td>100</td></tr>
<tr><td>10</td><td>Дүн</td><td colspan="2">46</td><td>96.7</td></tr>
</table>

## ҮР ДҮНТЭЙ ХЭРЭГЖСЭН ОНЦЛОХ АЖЛУУД:

“Мод тарих, арчлах аргачлал, ногоон байгууламжийн төлөвлөлт хийх талаар 1486, аялал жуулчлалын чиглэлээр 15, хог хаягдлын чиглэлээр 125, салбарын албан хаагчдад чадавхжуулах чиглэлээр 65, Биологийн олон янз байдлын чиглэлээр 24, Нийт 35 удаагийн сургалтад 4295 иргэн хамрагдсан. Уг арга хэмжээнд Байгаль хамгаалах нөхөн сэргээх арга хэмжээний зардлаас 3.1 сая төгрөгийг зарцуулав.

“Тэрбум мод” үндэсний хөдөлгөөн “Дундговио ногооруулъя” хөтөлбөрийн хэрэгжилт 94%-тай хэрэгжсэн бөгөөд “Бүх нийтээр мод тарих үндэсний өдөр”-өөр 141 аж ахуйн нэгж, байгууллагын 1284 иргэн 99944 мод, сөөгийг тарьж арчилгаа, усалгаа хийж, нийт модны тоо 285529-д хүрч, тарьсан модны талбайн хэмжээ өмнөх жилээс 4,2 хувиар өсөв. Улсын төсвөөр 326.0, орон нутгийн төсвөөр 72.0, хувийн хэвшлийн хөрөнгөөр 90.0 сая төгрөг зарцуулж, Нийт 99944 мод, сөөгийг тарьснаас 76.0 хувьтай ургуулсан байна.

“БҮХ НИЙТЭЭР МОД ТАРИХ ӨДӨР”-ИЙГ УГТСАН
“ДУНДГОВИО НОГООРУУЛЪЯ” ҮЗЭСГЭЛЭН ХУДАЛДАА






















Байгаль хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээний зардлаар хэрэгжүүлж буй Усны чиглэлээр Хүн амын унд ахуйн эх үүсвэр дээр усны дүн шинжилгээнд нийцсэн ундны ус, эрүүл ахуйн шаардлага, чанар аюулгүй байдлын стандартыг хангасан тус бүр 2 тн нөөцийн савтай цэвэршүүлэх төхөөрөмжийг Говь-Угтаал, Хулд, Эрдэнэдалай сумдад тус бүр 1, Адаацаг суманд 2, нийт 4 сумын 5 ундны усны эх үүсвэр дээр суурилуулж, 4 булгийн эхийг хашиж хамгаалж, 6 сумын 39 булгийн онцгой хамгаалалтын бүсэд тэмдэг байршуулж, 2 газарт зэрлэг амьтадыг ундаалах хөв цөөрөм байгуулсан байна. Орон нутгийн төсвөөс 125.3 сая төгрөг зарцуулсан нь үр дүнтэй хэрэгжсэн байна.





Монголд зочлох жилийн хүрээнд Цагаан суварга байгалийн үзэсгэлэнт газрын “Сэтгэшгүй оддын чуулган”, Их газрын чулуу байгалийн цогцолборт газар “Уяхан замбуу тивийн наран урлагийн их наадам”, Адаацаг сумын “Сүм хөх бүрд” байгалийн дурсгалт газарт “Адуучны өв соёлын баяр” зэрэг эвент арга хэмжээнд Нийт 4 эвент арга хэмжээнд 42583 гадаад, дотоодын жуулчид үзэж сонирхсон. Айхотел ХХК-тай хамтран ажиллах ДУЗДТГ-ОНХО/2022/35+1 гэрээ байгуулж Дундговь аялал жуулчлал, бизнес эрхлэгчдийн гар утасны платформыг хийлгэсэн зэрэг ажлуудыг

хүлээн авсан. Улс, орон нутгийн төсвөөс 170.5 сая төгрөг зарцуулсан нь үр дүнтэй хэрэгжсэн байна.

7.3 Байгаль, түүх, соёлын аялал жуулчлалын эвент зохион байгуулав







2023 онд Дундговь аймагт гадаад, дотоодын 79316 жуулчин ирсэн нь өмнөх оноос гадаад, дотоодын жуулчид 1 - 2 дахин өссөн үзүүлэлттэй байна.




| | 2019 | 2020 | 2021 | 2022 | 2023 |
|---|---|---|---|---|---|
| гадаад | 19540 | | 216 | 23264 | 31951 |
| дотоод | 5105 | 7100 | 15664 | 16650 | 47365 |

## ДӨРӨВ. ДҮГНЭЛТ

Монгол Улсын Засгийн газрын зарим чиг үүргийг орон нутагт төлөөлөн хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний жилийн эцсийн хэрэгжилтэд хяналт шинжилгээ, үнэлгээ хийж, үр дүнг 96.7 хувьтай буюу "Тодорхой үр дүнд хүрсэн" гэж үнэлж, үнэлгээний саналыг хүргүүлж байна.

Улсын тусгай хамгаалалттай газруудын менежментийн төлөвлөгөөг боловсруулах заалт нь Загийн ус, Дэлгэрхангай уул, Бага газрын чулуу улсын тусгай хамгаалалттай газруудад менежментийн төлөвлөгөө боловсруулах ажлыг Гурвансайхан ХХК, Эрдэнэс алт ресурс ХХК-д шаардлагатай төсөв мөнгийг менежментийн төлөвлөгөөнд тусгахаар саналыг хүргүүлсэн боловч хөрөнгө шийдэгдээгүй.

## ТАВ. ЗӨВЛӨМЖ

Хөгжлийн бодлого, төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтэст:

1. Засгийн газрын зарим чиг үүргийг орон нутагт төлөөлөн хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг боловсруулахдаа суурь түвшин, хүрэх түвшнийг судалгаа шинжилгээ болон бодлогын баримт бичгийн төлөвлөлттэй уялдуулан төлөвлөх

2. Тайланг гаргахдаа шалгуур үзүүлэлтийн дагуу хүрэх түвшинд хүрсэн эсэхийг тайлагнахаас гадна үр дүн, үр нөлөөний талаар тайлагнаж хэвших мөн нотлох баримтыг тайланд хавсаргаж байх

3. Дараа оны гэрээний төсөлд хэрэгжиж болохуйц, үр дүнтэй тодорхой ажлуудыг тусгуулахаар саналыг хүргүүлэх, Төсөв хөрөнгө нь тодорхойгүй ажлыг төлөвлөхгүй байхыг яам руу уламжилж хамтран ажиллах

БАТАЛГААЖУУЛСАН
АЙМГИЙН ЗАСАГ ДАРГА Ц.МӨНХБАТ

ХЯНАСАН
ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ ХЭЛТСИЙН
ДАРГА Д.ДААРИЙМАА

ТАЙЛАН БИЧСЭН
ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ ХЭЛТСИЙН
АХЛАХ МЭРГЭЖИЛТЭН Э.ОДОНЧИМЭГ

Дундговь аймгийн Засаг даргын 2023 оны
11 дүгээр сарын 29 өдрийн 01/1547 тоот
албан бичгийн 1 дүгээр хавсралт

# МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ЗАРИМ ЧИГ ҮҮРГИЙГ ОРОН НУТАГТ ТӨЛӨӨЛӨН 2023 ОНД ХЭРЭГЖҮҮЛЭХ ГЭРЭЭНИЙ ХҮРЭЭНД БАЙГАЛЬ ОРЧИН, АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН САЛБАРТ ХАМТРАН АЖИЛЛАХ 23-10 ТООТ ГЭРЭЭНИЙ БИЕЛЭЛТ

2023.11.29 Дундговь аймаг

| № | | Хэрэгжүүлэх арга хэмжээ | Зарцуулсан хөрөнгө | Үр дүнгийн үзүүлэлт | | | | Хувь |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | Шалгуур үзүүлэлт | Суурь түвшин | Хүрэх түвшин | Хүрсэн түвшин | |
| **1.Байгаль орчны холбогдох хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангах** | | | | | | | | |
| 1 | 1 | Байгаль орчны эсрэг гэмт хэрэг зөрчлийг бууруулах зорилгоор хамтарсан хяналт шалгалт зохион байгуулах | 4.0 БХНСАХЗ | Хяналт шалгалт хийсэн тоогоор | 51 | 30 | Төлөвлөгөөт хяналт шалгалтыг 12 объектод, төлөвлөгөөт бус хяналт шалгалтыг уул уурхайн 2 аж ахуйн нэгжид, урьдчилан сэргийлэх хяналт шалгалтыг 7 удаагийн удирдамжийн дагуу аялал жуулчлалын 22, уул уурхайн 39, нам даралтын зуух 4, шатахуун түгээх станц 6, засвар 2, нийт 73 аж ахуйн нэгж, 2 иргэнд хийсэн. Байгаль орчны эсрэг гэмт хэрэг зөрчлийг бууруулах хяналт шалгалтын хүрээнд нийт 89 удаагийн хяналт, шалгалтыг хийж 70 зөрчлийг арилгуулахаар улсын байцаагчийн 13 албан шаардлага хүргүүлж, 2 аж ахуйн нэгжид 3,500,000 төгрөгийн торгууль, 2 иргэнд амьтан, ургамлын экологи эдийн засгийн хохирлын үнэлгээ 2,368,931,6 төгрөгийн хохирлыг нөхөн төлүүлж, Зөрчлийн тухай хуулиар 450,000 төгрөгийн торгуулийн арга хэмжээ авсан. | 100 |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| 2 | 2 | Байгаль орчны салбарын хууль тогтоомжоор сургалт, сурталчилгаа зохион байгуулах | 3.1 БХНСАХЗ | Хамрагдсан иргэдийн тоо | 851 | 900 | **<u>Байгаль орчны тэмдэглэлт өдрүүдээр</u>**<br>"Ногоон-Ази" ТББайгууллагатай хамтран мод тарих, арчлах, мод үржүүлгийг үр болон модожсон мөчрөөр үржүүлэх сургалтыг 50 хүнд, Алимын мод тарих сургалтыг 140 хүнд, "Усны хэрэглээ, усаа хэмнэх энгийн аргууд", Усны талаарх мэдлэг сорих асуулт хариултын "quiz day"-ыг 35 сурагчдад, Сайнцагаан сумын 1 дүгээр цэцэрлэгийн 103 хүүхдэд "Дусал хүүгийн усаа хэмнэх 5 арга" зөвлөмж, ахлах ангийн 45 сурагчдад "One planet" netflix-ийн байгаль орчны баримтат киног тус тус үзүүлж, зохион байгуулав.<br>15 сум, аймгийн төвийн аж ахуйн нэгж, байгууллага, иргэдэд "Эх дэлхийн цаг"-т хэрхэн нэгдэх уриалга хүргүүллээ. Аймгийн төв талбайд "Эх дэлхийн цаг"-т талбайд, цахимаар, гэрээсээ нэгдсэн нийт 300 гаруй иргэд нэгдлээ.<br>Хаврын "Бүх нийтээр мод тарих өдөр"-өөр аймгийн хэмжээнд 791 иргэн мод тарилаа.<br>Намрын бүх нийтээр мод тарих өдрүүдээр "Ой мод" баримтат киног 2 сургуулийн нийт 30 хүүхдэд үзүүллээ.<br>"Дэлхийн байгаль хамгаалагчдын өдөр"-өөр 1 контент олон нийтийн сүлжээнд байршуулан сурталчиллаа.<br>"Дэлхийн аялал жуулчлалын өдөр"-өөр 9 байгууллагын 15 албан хаагчдад кофе уулзалт зохион байгууллаа.<br>**<u>Үзэсгэлэн худалдаагаар</u>**<br>"Дундговио ногооруулъя" үзэсгэлэн худалдаагаар 350 орчим иргэн үзэж сонирхож, худалдаа хийж, зөвлөгөө мэдээлэл авлаа.<br>**<u>Аж ахуйн нэгж байгууллага, боловсролын байгууллагад</u>**<br>Онцгой байдлын газар, Цагдаагийн газар, Тагнуулын хэлтэс байгууллагуудад, Хот тохижуулах газар, Луус сумын 5 төрийн байгууллага, Говийн-Ирээдүй цогцолбор сургууль, аймгийн төвийн айл өрхэд нийт 10 байгууллагын 115 иргэнд ногоон байгууламжийн төлөвлөлт, | 100 |
| | | | | Зохион байгуулсан сургалтын тоо | 30 | 35 | | |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | - | арчилгааны талбайн зөвлөгөө, сургалт, мэдээлэл өглөө. "Хүмүүнлэг" сургуулийн 8 дугаар ангийн сурагчид, "Политехникийн коллеж"-ийн ойн инженерийн ангийн багш оюутнууд нийт 40 хүнд мөчрөөр тарьц, суулгац хэрхэн ургуулах талаар талбайн сургалт зохион байгуулав. "Хог хаягдлыг хэрхэн бууруулах", "Аюултай хог хаягдал гэж юу вэ" сэдвээр ерөнхий боловсролын сургуулийн нийт 125 багш, сурагчдад сургалт зохион байгуулав. "НОГООН ИРЭЭДҮЙ" ТӨСӨЛ эх дэлхийн эзэн нь болоход хөтөлж Ногоон Ирээдүй сэдэвт сургалтыг 02 дугаар сарын 16-ны өдөр зохион байгуулж, 850 орчим ахлах ангийн сурагчдад оролцов. "Уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох үндэсний үйл ажиллагааны төлөвлөгөө" боловсруулахтай холбогдуулан танилцуулга сургалтыг 25 хүн зохион байгууллаа. Байгаль орчныг хамгаалах нийт 35 удаагийн сургалт, арга хэмжээ, үзэсгэлэн худалдаа, бусад үйл ажиллагаанд нийт 4295 иргэн хамрагдлаа. (Зураг хавсаргав) | |
| 3 | 3 | Мэдээллийн санд баяжилт хийх (eic.mn) | - | Оруулсан маягтын тоо | 86 | 86 | Аймгийн хэмжээнд 86 маягтын дагуу мэдээллийн санд 100% баяжилт хийлээ. | 100 |
| 4 | 4 | Иргэн, аж ахуйн нэгж байгууллагад цахим үйлчилгээ үзүүлсэн тоо | - | Цахим үйлчилгээ үзүүлсэн тоо (өссөн дүнгээр) | 12 | 20 | Ус ашиглуулах дүгнэлт гаргах, худаг гаргах зөвшөөрөл олгох үйлчилгээг 9, байгаль орчны нөлөөллийн ерөнхий үнэлгээний дүгнэлтийг 1 удаа, нийт 10 үйлчилгээ цахимаар үзүүлснээр цахим үйлчилгээний тоо өссөн дүнгээр 22 боллоо. | 100 |
| 5 | 5 | Байгалийн нөөцийн хамтын менежментийн нөхөрлөлийг дэмжих | - | Дэмжлэг үзүүлсэн тоо | 2 | 1 | Гурвансайхан сумын Гурвансайхан агнуурын бүсийн менежмент хариуцагчаас өвөлжилт хүндэрсэн нөхөрлөлийн 3 өрхөд 90 боодол өвс, 30 шуудай малын тэжээлийн дэмжлэг үзүүлэв. Мөн Их газрын чулуу улсын тусгай хамгаалалттай газарт шинээр "Саруул сүмбэр" нэртэй нөхөрлөл байгуулагдаж "Отголох цэг"-ийн менежментийг хариуцан ажиллаж байна. | 100 |
| 6 | 6 | "Иргэн бүр байгаль хамгаалагч" уриан дор | - | Идэвхтэн байгаль | 13 | 17 | Онцгой байдлын газраас явуулж буй Иргэн бүр байгаль хамгаалагч аянд нэгдэж, хамтран | 100 |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | байгаль орчныг хамгаалах, зөв дадал зуршил бий болгох зорилгоор идэвхтэн байгаль хамгаалагчийг нэмэгдүүлэх | | хамгаалаг чийг нэмэгдүүл сэн тоо (өссөн дүнгээр) | | | ажиллаж байна. Байгаль орчин, аялал жуулчлалын газраас сумдад Идэвхтэн байгаль хамгаалагчийн хүсэлт ирүүлэх тухай албан бичгийг хүргүүлж, Баянжаргалан сумаас 3 багийн 6 иргэн, Сайнцагаан сумын “Хаалган хад” орон нутгийн тусгай хамгаалалттай газарт 3 иргэнийг идэвхтэн байгаль хамгаалагчаар томилж, нийт 22 идэвхтэн байгаль хамгаалагч ажиллаж байна. | |
| 7 | 7 | Байгалийн нөөц ашигласны төлбөрийн тухай хууль, “Байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээнд зарцуулах төлбөрийн орлогын хэсгийг бүрдүүлэх, зарцуулах, тайлагнах журам”-ын хэрэгжилтийг хангах, хуулийн хэрэгжилтийг 100 хувьд хүргэх; | - | Хуулийн хэрэгжилт ийн хувь | 23 | 100 | Байгалийн нөөц ашигласны төлбөрийн тухай хуулийн 18.1-д заасны дагуу усны төлбөрийн орлогоос 319950.0 мян, амьтны орлогоос 194029.0 сая, газрын орлогоос 98121.1 мянган төгрөгийг байгаль хамгаалах арга хэмжээнд зарцуулахаар аймаг, сумын ИТХурал баталсан. Үүнээс газрын орлогоос санхүүжих арга хэмжээ 50%, усны орлогоос санхүүжих арга хэмжээ 87%, амьтны орлогоос санхүүжих арга хэмжээ 61%-тай хэрэгжиж, дундаж 66 хувийн зарцуулалттай байна. | 55.8 |
| 8 | 8 | 2024 оны байгалийн нөөц ашигласны төлбөрийн орлогын хувь хэмжээ, орлогоос зарцуулах арга хэмжээний төлөвлөлтийг Байгаль орчны төсөв зардлын мэдээллийн санд журамд заагдсан хугацаанд тогтмол оруулах (www.eic.mn) | - | Мэдээлли йн сан бүрдүүлсэ н хувь | 100 | 100 | “Байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээнд зарцуулах төлбөрийн орлогын хэсгийг бүрдүүлэх, зарцуулах, тайлагнах журам”-ын дагуу ус, газар, амьтны орлого гэсэн 3 төрлөөр гаргаж 2024 оны байгалийн нөөц ашигласны төлбөрийн орлого, гүйцэтгэх арга хэмжээ болон 2023 оны давсан орлогын хэмжээ, түүнээс хуулийн дагуу 2024 онд зарцуулах арга хэмжээний төлөвлөлтийг цагалбарын дагуу 2 удаа байгаль орчны мэдээллийн сан (www.eic.mn)-д 100% бүрэн оруулж, АЗДТГазарт нэгтгэн хүргүүлсэн. | 100 |
| **2. Ногоон хөгжлийн бодлогыг хэрэгжүүлэх** | | | | | | | | |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| 9 | 1 | Үйлдвэрлэл үйлчилгээний /уул уурхай, аялал жуулчлал, ШТС / бүс дэх нүхэн жорлонг үе шаттайгаар стандартын шаардлагад нийцүүлнэ | 90.0 Хувийн хэвшил | Үйлдвэрлэл, үйлчилгээний бүс дэх сайжруулсан ариун цэврийн байгууламж, эко жорлонгийн эзлэх хувь | 30.8 % | 33.8% | Байгаль орчин, аялал жуулчлалын газраас 8 жуулчны баазад стандартын шаардлага хангасан ариун цэврийн байгууламжтай болох, аялал жуулчлалын бүс нутагт цэвэрлэгээ зохион байгуулах тухай албан бичиг болон хогийн сав, ариун цэврийн байгууламжийн талаар мэдээлэл авах судалгааг хүргүүлсэн. Сайнцагаан сумын 13 шатахуун түгээх станцын ариун цэврийн байгууламжтай танилцан судалгаа хийж, шаардлага бүхий албан бичиг хүргүүлсэн. 4 шатахуун түгээх станц, 4 Аялал жуулчлалын бааз, 2 уул уурхайн ААН-д нийт 10 эко АЦБ нэмэгдэж Үйлдвэр үйлчилгээний бүс дэх эко жорлонгийн эзлэх хувь 50%-д хүрсэн. (Зураг хавсаргав) | 100 |
| 10 | 1 | Тогтвортой хөгжлийн боловсрол үндэсний хөтөлбөрийн хэрэгжилтийг хангаж, эко сургууль, цэцэрлэгийн тоог нэмэгдүүлэх | 0.8 БХНСАХ 3 | Хөтөлбөрт хамрагдсан сургууль цэцэрлэгийн тоо (өссөн дүнгээр) | 3 | 4 | Сайнцагаан сумын 1 дүгээр цэцэрлэг "Олон улсын эко сургууль, цэцэрлэг" хөтөлбөрт хамрагдаж "Хүрэл гэрэгэ" хүртэж, ахисан шатны 3 дахь сургалтад танхим болон цахимаар 3 удаа хамрагдахад дэмжлэг үзүүлснээр аймгийн хэмжээнд "Эко сургууль, цэцэрлэг хөтөлбөр"-т өссөн дүнгээр **5** сургууль, цэцэрлэг хамрагдсан. Мөн Эко сургууль, цэцэрлэгийн хүрэл гэрэгэт 1 дүгээр цэцэрлэгээс Эрдэнэдалай, Өлзийт, Өндөршил, Говь-Угтаал, Гурвансайхан сумдад "Эко сургууль, цэцэрлэг" хөтөлбөрийг танилцуулах сургалт зохион байгуулсан. (Зураг хавсаргав) | 100 |
| **3. Хүрээлэн буй орчин, байгалийн нөөцийг хамгаалах** | | | | | | | | |
| 11 | 1 | Агаарын чанарыг сайжруулах бүсэд мөрдөх журмыг хэрэгжүүлэх | - | Журмын хэрэгжилтийн хувь | 95.8 | 96 | Агаарын чанарыг сайжруулах бүсэд мөрдөх журмын хэрэгжилт 96.6 хувьтай хэрэгжиж хяналт шинжилгээ үнэлгээ хийгдсэн. | 100 |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| 12 | 2 | Мал, амьтны гоц халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх ажил зохион байгуулах | 0.8 ОНТ | Урьдчилан сэргийлэх үйл ажиллагааны тоо | 2 | 2 | Мал, амьтны гоц халдварт өвчнөөс урьдчилсан сэргийлэх чиглэлээр олон нийтийн сүлжээгээр сэрэмжлүүлэх 5 удаагийн мэдээлэл хүргэж, Хулд, Луус, Өлзийт, Сайнцагаан, Адаацаг, Эрдэнэдалай, Гурвансайхан, Дэлгэрцогт, Цагаандэлгэр сумдын нутгаар 6 удаа хяналт шалгалт хийсэн. 2 сард Луус суманд 1 үнэг галзуу өвчнөөр, 9 сард Хулд суманд хууль бусаар цагаан зээр агнах зөрчил бүртгэгдсэнийг амьтны экологи эдийн засгийн хохирлын үнэлгээ 1,994,000 төгрөгийн хохирлыг нөхөн төлүүлж, зөрчлийн тухай хуулиар 150,000 төгрөгийн торгуулийн арга хэмжээ авч, халдварт өвчин дэгдэхээс урьдчилан сэргийлж устгах ажлыг Мал эмнэлгийн газартай хамтран зохион байгуулав. Иргэдийн хууль, эрх зүйн мэдлэгүйгээс болж өр төлбөрт орохоос урьдчилан сэргийлэх үүднээс Монгол Улсын Засгийн газрын 2023 оны 260 дугаар тогтоолоор Амьтны экологи - Эдийн засгийн үнэлгээ шинэчлэн батлагдсаныг цахим сайтад 2, олон нийтийн сүлжээнд 3, мэдээллийн самбарт 1 удаа байршуулсан. | 100 |
| 13 | 3 | Зэрлэг амьтдад зориулж, биотехникийн арга хэмжээ авах | 1.8 ОНТ 2.0 Хувийн хэвшил | Биотехникийн арга хэмжээний тоо | 20 | 15 | Тус аймгийн улс, орон нутгийн тусгай хамгаалалттай газарт байрлах 6 агнуурын бүсэд 35 боодол өвс, 8 тонн хужир, мараа тавьж зэрлэг амьтдад биотехникийн арга хэмжээг давхардсан тоогоор 45 удаа авч хэрэгжүүлэв. Тусгай хамгаалалттай 8 газарт зэрлэг амьтан ажиглах камер байрлуулж, зэрлэг амьтдын хоол тэжээлийн байдал, хууль бус ан зэрэгт хяналт тавив. | 100 |
| 14 | 4 | Ашигт малтмалын ашиглалтын тусгай зөвшөөрөл эзэмшигч аж ахуйн нэгж бүрийн 2023 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөөний биологийн олон янз байдлыг дүйцүүлэн хамгааллын арга хэмжээг гүйцэтгүүлэх | 92.7 Хувийн хэвшил | Дүйцүүлэн хамгааллын арга хэмжээ авсан аж ахуйн нэгжийн тоо | 12 | 10 | Уул уурхайн үйл ажиллагаа явуулдаг аж ахуйн нэгжүүдийн байгаль орчны өмнө хүлээх хариуцлага, үүргийг гүйцэтгүүлэх зорилгоор үйл ажиллагаа явуулж буй 6 суманд 17 дүйцүүлэн хамгааллын арга хэмжээг төлөвлөж, эвдэрч эзэнгүй орхигдсон 5.1 га талбайд техникийн нөхөн сэргээлт, 9350 ширхэг мод тарьж, улс, орон нутгийн тусгай хамгаалалттай газарт 12 ширхэг камер, 1 худаг амьтан услах сан байршуулж, биотехникийн арга хэмжээ авч ажиллалаа. Нийт 12 | 100 |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | ААНэгж байгаль орчны менежментийн төлөвлөгөөний хүрээнд дүйцүүлэн хамгааллын арга хэмжээг хэрэгжүүлэв. (Зураг хавсаргав) | |
| 15 | 5 | Хог хаягдлыг эх үүсвэр дээр нь бууруулах, дахин ашиглах, дахин боловсруулах 3R цогц менежментийг хэрэгжүүлж эдийн засгийн эргэлтэд оруулах | 36.8<br>ОНТ<br>10.0<br>Төсөл хөтөлбөр | Хог хаягдлыг эх үүсвэр дээр ангилан ялгасан хэмжээ (тн) | 17 | 17 | Адаацаг, Дэрэн, Сайхан-овоо, Эрдэнэдалай суманд дахивар авах цэг шинээр байгуулагдаж, аймгийн хэмжээнд хог хаягдлыг эх үүсвэр дээр ангилан дахивар цуглуулах 7 цэгтэй болсноор нийт 81 тн дахивар цуглуулсан. Үүнээс дахин боловсруулах үйлдвэрт 40 тн дахивар нөөц тушаасан. (Зураг хавсаргав) | 100 |
| 16 | 6 | Сумын төвүүдэд гуравдугаар зэрэглэлийн хог хаягдлын төвлөрсөн цэгийн ландфилл байгуулах | 35.5<br>ОНТ<br>50.0<br>Хувийн хэвшил | Төвлөрсөн цэгийн тоо | - | 1 | Эрдэнэдалай сумын хогийн цэгийн 16 га талбайг хашаажуулан камер суурилуулж харуулын байр тохижуулан тогтмол харуул хамгаалалттай болгож 3-р зэрэглэлийн ландфилл байгуулснаар хогийн цэгийн талбайн хэмжээ 9 га – аар буурсан. Мөн хог хаягдал тээвэрлэх машин шинээр худалдаж авсан. (Зураг хавсаргав) | 100 |
| 17 | 7 | Хууль бус ашигт малтмал олборлолтыг таслан зогсоох хяналт шалгалтыг эрчимжүүлэх | 0.2<br>ОНТ | Хяналт шалгалтын тоо | 3 | 2 | Дундговь аймгийн Өлзийт сумын 1-р багийн нутаг “Загийн ус” улсын тусгай хамгаалалттай газарт түгээмэл тархацтай ашигт малтмал буюу элс зөөвөрлөсөн талаар улсын тусгай хамгаалалттай газрын байгаль хамгаалагчийн мэдээллийн дагуу газар дээр нь сумын хэсгийн төлөөлөгч, байгаль орчны хамтарсан ажлын хэсэг нөхцөл байдалтай танилцан 2 машин элс ачсан зөөвөрлөх гэж байсан иргэнийг саатуулан, элс зөөвөрлөсөн газрын талбайн хэмжээг тодорхойлон зөрчлийг арилгуулахаар Цагдаагийн байгууллагад шилжүүлсэн. Гурвансайхан сумын 4-р баг Өндөр-Элст гэх газарт хайгуулын тусгай зөвшөөрөлтэй “Жеймэр сурвэй” ХХК ашиглалтын үйл ажиллагаа явуулж байна гэх нутгийн иргэдийн гомдлоор экологийн цагдаагийн алба, уул уурхайн байцаагчдын хамтарсан хяналт, шалгалт хийж үйл | 100 |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | ажиллагааг зогсоосон. Төлөвлөгөөт бус хяналт, шалгалтыг "Монгол Росцветмет" ХХК-д иргэний гомдлын дагуу хяналт шалгалт хийж 4 зөрчлийг илрүүлэн улсын байцаагчийн албан шаардлага өгч зөрчлийг бүрэн арилгасан. Хууль бус ашигт малтмал олборлолттой холбоотой хяналт шалгалтыг 4 удаа хийж ажилласан. 2022 онд хууль бус ашигт малтмал олборлолттой холбоотой зөрчил 6 илэрсэн. 2023 онд 3 болж буурсан үзүүлэлтэй байна. | |
| 18 | 8 | Эвдэрч, эзэнгүй орхигдсон талбайд нөхөн сэргээлт хийх | 40.0 Хувийн хэвшил | Нөхөн сэргээсэн талбайн хэмжээ (га) | 5 | 5 | 2023 онд уул уурхайн ашиглалтын үйл ажиллагаа эрхэлдэг 7 аж ахуйн нэгж 4 сумдын эвдэрч, эзэнгүй орхигдсон 7 байршилд 5.1 га газарт техникийн нөхөн сэргээлт хийгдэж, эвдэрч эзэнгүй орхигдсон газрын хэмжээ 13 хувиар буурсан үзүүлэлттэй байна. (Зураг хавсаргав) | 100 |
| 19 | 9 | "Нөхөн сэргээлт-2024" нэгдсэн арга хэмжээний аймгийн дэд ажлын хэсгийн үйл ажиллагааг эрчимжүүлж, дэмжиж ажиллах | - | Төлөвлөгөөний хэрэгжилтийн хувь | 90 | 96 | Байгаль орчин, аялал жуулчлалын яамнаас "Нөхөн сэргээлт-2024" нэгдсэн арга хэмжээ зохион байгуулах орон нутгийн дэд ажлын хэсгүүдтэй хийсэн цахим хуралд Дундговь аймгийн Засаг даргын орлогч, Байгаль орчин, аялал жуулчлалын газрын дарга мэргэжилтнүүд, ХБТХОХэлтсийн мэргэжилтэн, Экологийн асуудал хариуцсан эрүүгийн мөрдөгч нар оролцсон. Мөн эвдэрсэн газрын тооллого мэдээллийн ажлыг аймгийн хэмжээнд зохион байгуулж нэгдсэн тоо хэмжээг шинэчлэн гаргаж БОАЖЯаманд хүргүүлсэн.<br>"Нөхөн сэргээлт-2024" нэгдсэн арга хэмжээний аймгийн төлөвлөгөө 97 хувьтай хэрэгжсэн бөгөөд эвдэрсэн газрын тооллого, мэдээлэл шинэчлэгдэж, нийт 25.5 га талбайд техник, биологийн нөхөн сэргээлт хийгдэв.(Зураг хавсаргав) | 100 |
| **4.Усны нөөцийн ашиглах, хамгаалах** | | | | | | | | |
| 20 | 1 | Булгийн эхийг хашиж хамгаалах, тохижуулах ажлыг зохион байгуулах | 20.0 БХНСАХ 3 | Хашсан булгийн тоо | 59 | 64 | Адаацаг сумын "Баянхошууны булаг", Хулд сумын "Балын булаг", Сайхан-Овоо сумын "Дэлгэрэхийн булаг" Гурвансайхан сумын Илжигэнт нийт 4 булгийн эхийг хашиж хамгаалах ажлыг хийж | 80 |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | 5.0 Хувийн хэвшил | | | | гүйцэтгэв. Тус ажлын гүйцэтгэлийг аймгийн Засаг даргын 2023 оны 10 дугаар сарын 02-ны А/571 тоот захирамжаар байгуулагдсан ажлын хэсэг газар дээр нь актаар хүлээн авлаа. 4 булгийн эхийг хашиж хамгаалснаар 14 өрхийн бог, бод нийлсэн 17000 мал ундаалах нөхцөл бүрдэж бэлчээрийн усан хангамжийг нэмэгдүүлэв. Нийт хашсан булгийн тоо 63 болж нэмэгдэв. (Зураг хавсаргав) | |
| 21 | 2 | Усны сан бүхий газарт тэмдэгжүүлэлтийн ажил зохион байгуулах | 5.3 БХНСАХ 3 | Тэмдэгжүүлсэн булгийн тоо | 37 | 30 | Усны сан бүхий газарт тэмдэг, тэмдэглэгээг Адаацаг 21, Гурвансайхан 7, Сайхан-Овоо 2, Хулд 2, Өндөршил 3, Эрдэнэдалай 4, нийт 6 сумын 39 булгийн онцгой хамгаалалтын бүсэд байршуулж, аймгийн хэмжээнд нийт 98 булгийн онцгой хамгаалалтын бүсийг тэмдэгжүүлэв. Тэмдэгжүүлэлт хийснээр онцгой хамгаалалтын бүсэд ашигт малтмалын тусгай зөвшөөрөл олгогдохгүй. (Зураг хавсаргав) | 100 |
| 22 | 3 | Төв суурин газрын ундны усны чанар стандартыг сайжруулан цэвэршүүлэх төхөөрөмжийг ус хангамжийн 1 эх үүсвэрт суурилуулах | 80.0 ОНТ | Суурилуулсан төхөөрөмжийн тоо | 2 | 1 | Хүн амын унд ахуйн эх үүсвэр дээр усны дүн шинжилгээнд нийцсэн ундны ус, эрүүл ахуйн шаардлага, чанар аюулгүй байдлын стандартыг хангасан тус бүр 2 тн нөөцийн савтай цэвэршүүлэх төхөөрөмжийг Говь-Угтаал, Хулд, Эрдэнэдалай сумдад тус бүр 1, Адаацаг суманд 2, нийт 4 сумын 5 ундны усны эх үүсвэр дээр суурилуулав. | 100 |
| 23 | 4 | Хөв цөөрөм байгуулах | 20.0 ОНТ 2.0 хувийн хэвшил | Хөв цөөрөм байгуулсан тоо | 1 | 1 | Дэлгэрцогт сумын "Бага газрын чулуу" улсын тусгай хамгаалалттай газрын Чулуун эргийн "Дугуй булаг", Баянжаргалан сумын "Оргихын булаг"-ийг түшиглэн 14 $м^3$ хэмжээ бүхий 2 ширхэг хөв цөөрмийг ногоон байгууламжийн усалгаа болон зэрлэг амьтан ундаалах зорилгоор байгуулав. (Зураг хавсаргав) | 100 |
| 24 | 5 | Ус бохирдуулагчийн эх үүсвэрийн тооллого хийх | - | Тооллогод хамрагдсан байгууллага, аж ахуйн | - | 50 | Сайхан-Овоо, Гурвансайхан, Эрдэнэдалай, Адаацаг, Луус, Дэрэн, Дэлгэрцогт, Өндөршил суманд үйл ажиллагаа явуулж байгаа төрийн болон хувийн хэвшлийн 56 аж ахуйн нэгж, | 100 |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | нэгжийн тоо | | | байгууллагад ус бохирдуулагчийн тооллого зохион байгуулж хаягдал усны хэрэглээг тодорхойлж, 304 мкүб усны төлбөрийн орлого нэмэгдэх боломжтой болсон. (Зураг хавсаргав) | |
| **5.Тусгай хамгаалалттай газар нутгийг хамгаалах** | | | | | | | | |
| 25 | 1 | Улс, орон нутгийн тусгай хамгаалалттай газрын самбарын мэдээллийг шинэчлэх | 1.0 БХНСАХ 3, Хувийн хэвшил | Байршуулсан мэдээллийн тоо | 1 | 2 | "Бага газрын чулуу", "Дэлгэрхангай уул" улсын тусгай хамгаалалттай газруудын мэдээллийн самбарыг шинэчилсэн. Үүний үр дүнд гадаад, дотоодын иргэд тусгай хамгаалалттай газар нутаг, амьтны экологи эдийн засгийн үнэлгээ, холбогдох хууль тогтоомжийг мэдэх боломжийг бүрдүүлж ажиллав. | 100 |
| 26 | 2 | Улсын тусгай хамгаалалттай газруудын менежментийн төлөвлөгөөг боловсруулах | - | Менежментийн төлөвлөгөө боловсруулсан эсэх | - | 1 | "Загийн ус", "Дэлгэрхангай уул", "Бага газрын чулуу" улсын тусгай хамгаалалттай газруудад менежментийн төлөвлөгөө боловсруулахаар Гурвансайхан ХХК, Эрдэнэс силвер ХХК-аар хийлгэхээр шаардлагатай төсөв мөнгийг төлөвлөгөөнд тусгуулан ажиллав. Мөн тусгай хамгаалалттай газрын менежментийн төлөвлөгөө боловсруулдаг мэргэжлийн байгууллага болох "ДЭ НЭЙЧЕ КОНСЕРВАНСИ" байгууллагын Монгол дахь төлөөлөгчийн газарт хүсэлт хүргүүлэв. Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар Өлзийт сумын Цагаан суварга, Дэл уулын тусгай хамгаалалттай газарт аялал жуулчлал хөгжүүлэх ерөнхий төлөвлөгөөг "Нарт дизайн" ХХК-аар хийж гүйцэтгүүлэн аймгийн ИТХ-ын ээлжит 15 дугаар хуралдаанаар хэлэлцэн батлагдсан. Мэргэжлийн байгууллагаар хийх санхүүжилт шийдэгдээгүй учраас хэрэгжилт удааширч байна. 2024 оны төлөвлөгөөнд тусган ажиллаж байна. | 30 |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| 27 | 3 | Улсын тусгай хамгаалалттай газар нутагт зөрчлөөс урьдчилан сэргийлэх хамтарсан хяналт шалгалт хийх | - | Хамтарсан хяналт шалгалтын тоо | 4 | 4 | “Дэлгэрхангай уул” улсын тусгай хамгаалалттай газарт хууль бус ан, “Загийн ус” улсын тусгай хамгаалалттай газарт хууль бус заг мод бэлтгэл, “Их газрын чулуу” улсын тусгай хамгаалалттай газар хууль бус ан болон хүнд даацын тээвэр зэрэг зөрчлүүдээс урьдчилан сэргийлж байгаль орчны хяналтын улсын байцаагч, сумын хэсгийн төлөөлөгч, байгаль хамгаалагч нартай хамтарсан хяналт шалгалт 9 удаа хийж гүйцэтгэв. Үүнээс Өлзийт сумын хэсгийн төлөөлөгчтэй хамтран “Загийн ус” улсын тусгай хамгаалалттай газраас Заг мод түүж бэлтгэсэн зөрчлийн хэргийг нээн шалгаж холбогдогчид шинжээчийн дүгнэлтээр тогтоогдсон Экологи эдийн засгийн хохирлын үнэлгээ 374,931,6 төгрөгийн хохирлыг нөхөн төлүүлж, Зөрчлийн тухай хуулийн дагуу 300,000 төгрөгийн торгуулийн арга хэмжээ авч, зөрчлийн тоо өмнөх жилээс 1 дахин буурсан үзүүлэлттэй байна. | 100 |
| 28 | 4 | Улсын тусгай хамгаалалттай газрын хамгаалалтын захиргаатай хамтран тусгай хамгаалалттай газрын орчны бүсэд амьдарч буй иргэдэд Байгаль орчныг хамгаалах чиглэлээр сургалт, сурталчилгааны ажлыг зохион байгуулах | - | Сургалт сурталчилгаа хийсэн тоо | 2 | 4 | “Их газрын чулуу” байгалийн цогцолборт газрын хамгаалалтын захиргаатай хамтран орчны бүсэд амьдарч буй иргэдэд хууль бус ан, улсын тусгай хамгаалалттай газрын дүрэм, мод тарих, чиглэлээр 5 удаа сургалт зохион байгуулж 34 хүнийг хамруулан, мэдлэг мэдээлэл өгч ажиллалаа. Үүний үр дүнд Их газрын чулуу улсын тусгай хамгаалалттай газарт шинээр “Саруул сүмбэр” нэртэй нөхөрлөл байгуулагдаж “Отоглох цэг”-ийн менежментийг хариуцан ажиллаж байна. | 100 |
| **6.Ойн бодлого, “Тэрбум мод” хөдөлгөөнийг өрнүүлж, зорилтын хэрэгжилтийг хангах** | | | | | | | | |
| 29 | 1 | Орон нутгийн хөрсөнд дасан зохицсон тарьц, суулгац бэлтгэх мод үржүүлгийн газар шинээр байгуулах | 250.0 ҮТ | Шинээр байгуулсан мод үржүүлгийн тоо | 2 | 1 | Дэлгэрцогт, Хулд, Баянжаргалан сумдад нийт 11 га-д мод үржүүлгийн газар байгуулахаар газар зохион байгуулалтын төлөвлөгөөнд тусган батлуулж Сайнцагаан сумын 4-р багийн нутагт 3 га газарт Жимс, жимсгэнийн суулгац үржүүлгийн төвийг байгуулж хамгаалалтын зурваст улиас, хайлаас зэрэг 875 мод, жимс, жимсгэнийн суулгац | 100 |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | 7 төрлийн 1500, нийт 2375 ширхэг мод, сөөгийг тарьж дуслын усалгааны системд холбож цэнэг усалгаа хийв. Тус мод үржүүлгийн газар байгуулагдсанаар 10000 – 15000 суулгац нийлүүлэх боломж бүрдсэн. | |
| 30 | 2 | Үржүүлгийн зориулалтаар мод, сөөгийн үр, мөчрийн нөөц бүрдүүлэх ажлыг зохион байгуулах | 10.0 ОНТ | Бэлтгэсэн үрийн хэмжээ (КГ) | 55.5 | 56 | Хайлаасны 33 кг үр түүж, бэлтгэн шууд тарилт хийсэн. Бүйлс 7,5 кг, Жигд 3 кг, Голт бор 0,5 кг, Агч 2 кг, Заг 10 кг, Шар хуайс 2 кг, нийт 56 кг үрийг тус тус бэлтгэв. ӨМӨЗОрны Хянган аймгаас тусламжийн хүрээнд ирсэн 1,5 тн харганы үрийг Эрдэнэт хотын "Ойн генетик нөөц"-ийн үрийн агуулахад хадгалуулж байна. Улиасны мөчир 10500 ширхэг, улаан сухайн мөчир 9800 ширхгийг бэлтгэж мод үржүүлгийн газарт тарьж цэнэг усалгаа хийж өвөлжилтөд бэлтгэв. (Зураг хавсаргав) | 100 |
| | | | | Үржүүлсэн мөчрийн тоо | 19300 | 19500 | | |
| 31 | 3 | Мод, сөөг, тарьц, суулгацыг ногоон байгууламжид гаргах | - | Нийлүүлсэн тарьц, суулгацын тоо | 16400 | 17000 | Сум дундын ойн ангийн Мод үржүүлгийн газраас орон нутгийн хөрсөнд дасан зохицсон 13000, "Байгалиа дээдэлье" ХХК-ны үржүүлсэн 34270, нийт чанарын шаардлага хангасан 47270 ширхэг тарьц суулгацыг иргэд, аж ахуйн нэгж, байгууллагад нийлүүлэв. (Зураг хавсаргав) | 100 |
| 32 | 4 | Ойн зурвас байгуулах | - | талбайн хэмжээ (га) | 5 | 5 | Сайхан-Овоо, Өлзийт, Дэлгэрцогт, Говь-Угтаал, Сайнцагаан суманд 18 га, авто зам дагуу 25 га, ногоон говь төслөөр 2 га мод тарьж нийт 45 га талбайд ойжуулалт, ойн зурвас байгуулснаар аймгийн хэмжээнд нийт талбайн хэмжээ 427,7 га-д хүрэв.(Зураг хавсаргав) | 100 |
| 33 | 5 | Ногоон байгууламжийг нэмэгдүүлэхэд иргэн, хувийн хэвшлийг татан оролцуулж, мэргэжил арга зүйн дэмжлэг үзүүлэн хамтарч ажиллах | 90.0 Хувийн Хэвшил | Тарьсан модны тоо (өссөн дүнгээр) | 185585 | 235000 | "Тэрбум мод" үндэсний хөдөлгөөн "Дундговио ногоорууlъя" хөтөлбөрийн хүрээнд "Бүх нийтээр мод тарих үндэсний өдөр"-өөр 141 аж ахуйн нэгж, байгууллагын 1284 иргэн 99944 мод, сөөгийг тарьж арчилгаа, усалгаа хийж, нийт модны тоо 285529-д хүрч, тарьсан модны талбайн хэмжээ өмнөх жилээс 4,2 хувиар өсөв. | 100 |
| **7. Аялал жуулчлалыг хөгжүүлэх** | | | | | | | | |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| 34 | 1 | Ай Ти Эм олон улсын аялал жуулчлалын үзэсгэлэнд нэгдсэн зохион байгуулалттай оролцох | 2.0 ОНТ 3.4 Хувийн хэвшил | Оролцсон аж ахуйн нэгжийн тоо | 8 | 8 | ITM 2023 олон улсын аялал жуулчлалын үзэсгэлэнд Дундговь аймгийн Засаг даргын Тамгын газар, Байгаль орчин, аялал жуулчлалын газар, Говийн шуранхай АЖхолбоо, Цагаан суварга, Эрдэнэ-Ухаа, Баянбулаг, Онги-Энержи, Бага газрын чулуу, Говь хулан, Сүм хөх бүрд, Ачлал-Оргил, Бага газрын хүрээ гэсэн 12 аж ахуйн нэгж, байгууллага нэгдсэн зохион байгуулалттай оролцож, тур оператор компаниудтай 2024 онд жуулчин хүлээн авах 634 гэрээ байгуулж, 5850 тараах материал тарааж ажиллалаа. | 100 |
| 35 | 2 | Аялал жуулчлалын сургалт, өдөрлөг зохион байгуулах | - | Зохион байгуулсан арга хэмжээний тоо | 2 | 2 | Политехникийн коллежтой хамтран аялал жуулчлалын салбарын "Нээлттэй ажлын байрны өдөрлөг сургалтад"-д аж ахуйн нэгж байгууллагын 56 сурагч, ажилчид, Дэлхийн аялал жуулчлалын өдрийг угтан Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого төлөвлөлтийн хэлтсийн харьяа 7 агентлагийг оролцуулсан "Кофетой уулзалт"-д 18, Ай Ти Эм үзэсгэлэнгийн үеэр жуулчны баазуудад зориулсан сургалтад 9 аж ахуйн нэгжийн 12 хүнийг сургалтад хамруулж, нийт 3 удаагийн сургалтад 86 ажилчдыг хамруулж, тус аймагт ирсэн гадаад жуулчдын тоо 1 дахин өссөн үзүүлэлттэй байна.(Зураг хавсаргав) | 100 |
| | | | | Хамрагдсан ажилчдын тоо | - | 50 | | |
| 36 | 3 | Байгаль. түүх, соёлын аялал жуулчлалын эвент (Тэмээчний өв соёлын баяр, Адуучин, айргийн баяр) арга хэмжээг зохион байгуулах | 10.0 УТ 46.5 ОНТ | Зохион байгуулсан арга хэмжээний тоо | 2 | 2 | Хулд суманд 01 дүгээр сарын 27-ны өдөр "ТЭМЭЭНИЙ ӨВ СОЁЛ" эвент арга хэмжээг зохион байгуулж, Өмнөговь аймгийн 7 сум, Дундговь аймгийн 3 сумын тэмээчид оролцож, гадаад, дотоодын 518 жуулчид үзэж, сонирхсон. Цагаан суварга дахь "Говь каравансерай" жуулчны баазтай хамтран "Сэтгэшгүй оддын чуулган" эвент арга хэмжээг зохион байгуулж 165 аялагч, жуулчид үзэж сонирхсон. Дуу хуур, өв, соёлын өлгий нутгийн бренд болсон Уяхан замбуу тивийн наран урлагийн их наадмыг Их газрын чулуу БЦГазарт зохион байгуулж 15 сумын 3200 морин хуурч, уртын дуучид оролцож, зохион байгуулах багийн 1000 хүн, гадаад, дотоодын 41000 хүн үзэж сонирхсон. Адаацаг сумын Сүм хөх бүрд байгалийн үзэсгэлэнт газарт Адуучны өв соёлын баяр" эвент арга хэмжээг зохион байгуулж 4 | 100 |
| | | | | Арга хэмжээнд хамрагдсан иргэдийн тоо | 1650 | 2500 | | |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | аймгийн 72 адуучин залуус оролцож, 900 гаруй зочид төлөөлөгчид үзэж сонирхсон. Нийт 4 эвент арга хэмжээнд 42583 гадаад, дотоодын жуулчид үзэж сонирхсон. (Зураг хавсаргав) | |
| 37 | 4 | Цагаан суварга, Их газрын чулуу 2 отоглох цэгийн ашиглалт хамгаалалтын менежментийг гэрээний үндсэн дээр хувийн хэвшил, мэргэжлийн холбоодоор хийж гүйцэтгүүлэх, орон нутгийн өмчид бүртгэж хүлээн авах | - | Орон нутгийн өмчид бүртгэсэн эсэх | - | тийм-1, үгүй -0 | 2022 онд тус аймгийн Гурвансайхан сумын Их газрын чулуу, Өлзийт сумын Цагаан суварга байгалийн үзэсгэлэнт 2 газарт байгуулсан. "Отоглох цэг"-ийг орон нутгийн өмчид бүртгэж, менежмент хариуцагчийг сонгон шалгаруулж, гэрээ байгуулсан. Их газрын чулуу байгалийн цогцолборт газрын "Отоглох цэг"-ийг Саруул сүмбэр нөхөрлөлд, Цагаан суварга байгалийн үзэсгэлэнт газрын "Отоглох цэг"-ийг байгаль хамгаалагч Б.Бадрахад хариуцуулж, гэрээ байгуулсан. 2023 онд Цагаан суварга Отоглох цэгт 122 машин 284 аялагч, Их газрын чулууны Отоглох цэгт 526 машины 1251 аялагч, нийт 648 машин, 1535 дотоод, гадаадын жуулчдад үйлчилсэн. | 100 |
| | | | | Отоглох цэгийн ашиглалтын менежмент хэрэгжүүлсэн тоо | - | 2 | | |
| **8. Уур амьсгалын өөрчлөлтийг сааруулах, дасан зохицох үйл ажиллагаа (Нэмэлтээр хийсэн ажил)** | | | | | | | | |
| 38 | 1 | 2022 онд Чип багц суурилуулах гэрээ байгуулсан өрхүүдэд багцыг тараан хэрэглээнд нэвтрүүлэх | 208.0 төсөл хөтөлбөр | Хэрэглээнд нэвтрүүлсэн өрхийн тоо (өссөн тоо) | 20 | 50 | НҮБ-ын Хүүхдийн Сан болон Монгол Улсын Засгийн Газрын хамтран хэрэгжүүлж буй "Эх хүүхдийн эрүүл мэндэд үзүүлэх агаарын бохирдлын нөлөөллийг бууруулах хөтөлбөр"-ийн хүрээнд монгол гэрийн дулаалга, халаалт, агаар сэлгэлтийн ЧИП төслийн хүрээнд Чип багц 2023 оны байдлаар 64 өрхөд олгогдож ашиглаж байна. 2023 оны 5 сарын 09-нд НҮБ-ын Хүүхдийн сангаас "Монгол гэрийн дулаалга чип багц" төслийн танилцуулга, туршлага судлах уулзалтад Сайнцагаан сумын багийн дарга нийгмийн ажилтнууд, төслийн ажлын хэсэг, хэрэглэгчдийн төлөөлөл оролцож мэдээлэл солилцов. 4-р улирал бүрэн хэрэглээнд нэвтрүүлсэн. Иргэдийн хэрэгцээ шаардлагыг тодорхойлох зорилгоор цахим асуулга авсан бөгөөд 300 иргэн Чип багц хэрэглэх хүсэлт гаргасан. Чип багцын талаарх танилцуулсан хэрэглэгчдийн сэтгэгдэл бүхий видео контент бэлтгэж цахимаар түгээсэн. | 100 |
| **9. Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар гүйцэтгүүлэх ажлууд** | | | | | | | | |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| 39 | 1 | “Хөрс хамгаалах, газрын доройтлыг бууруулах үндэсний хөтөлбөр”-н хүрээнд цөлжилт, газрын доройтлыг бууруулах зорилгоор ойн зурвас байгуулах | - | Ойн зурвас байгуулсан талбайн хэмжээ (га) | 8 | 50 | Улсын төсвөөр хийлгүүлэх саналтай сайдын гэрээнд санал хүргүүлсэн боловч төсөв нь батлагдаагүй тул хэрэгжээгүй. | - |
| 40 | 2 | Бага газрын чулуу” улсын тусгай хамгаалалттай газарт боловсон ариун цэврийн байгууламж байгуулах | - | Ариун цэврийн байгууламжийн тоо | - | 1 | Улсын төсвөөр хийлгүүлэх саналтай сайдын гэрээнд санал хүргүүлсэн боловч төсөв нь батлагдаагүй тул хэрэгжээгүй. | - |
| 41 | 3 | Онгийн хийдийн байгалийн үзэсгэлэнт газарт ариун цэврийн байгууламж байгуулах | - | Ариун цэврийн байгууламжийн тоо | - | 1 | Улсын төсвөөр хийлгүүлэх саналтай сайдын гэрээнд санал хүргүүлсэн боловч төсөв нь батлагдаагүй тул хэрэгжээгүй. | - |
| 42 | 4 | Бичил уул уурхайн улмаас эвдэрсэн газарт техникийн нөхөн сэргээлт хийх | - | Нөхөн сэргээлт хийсэн талбайн хэмжээ (га) | - | 20 | Улсын төсвөөр хийлгүүлэх саналтай сайдын гэрээнд санал хүргүүлсэн боловч төсөв нь батлагдаагүй тул хэрэгжээгүй. | - |
| 43 | 5 | Бага газрын чулуу” улсын тусгай хамгаалалттай газарт тарвага нутагшуулах ажлыг зохион байгуулах | Хувийн хэвшил 35.0 | Нутагшуулсан тарваганы тоо | 50 | 50 | "Монгол тарвага"-ыг хамгаалах, өсгөх үржүүлэх зорилгоор “Их газрын чулуу” улсын тусгай хамгаалалттай газарт 2023 онд 50 тарвага нутагшуулах ажлыг Эрдэнэс монгол ХХК-н хийж гүйцэтгэв. | 100 |
| 44 | 6 | “Тэрбум мод үндэсний хөдөлгөөн”-ий хүрээнд ойн зурвас байгуулах | 76.0 УТ | Ойн зурвас байгуулсан талбайн хэмжээ (га) | - | 30 | Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар “Тэрбум мод үндэсний хөдөлгөөн”-ий хүрээнд Сайхан-Овоо суманд 5 га талбайд шинээр ойн зурвас байгуулсан. Аймгийн Засаг даргын 2023 оны А/607 дугаар захирамжаар байгуулагдсан ажлын хэсэг газар дээр нь ажиллаж 90 хувь ургалттай тогтоон актаар хүлээн авсан. (30 га ойн зурвас байгуулах санал хүргүүлж 5 га ойн зурвас байгуулах төсөв батлагдсан. Батлагдсан төсөвт ажил хийгдсэн) | 100 |
| 45 | 7 | Усны чанар стандартыг сайжруулан цэвэршүүлэх төхөөрөмжийг ус хангамжийн эх үүсвэрт суурилуулах | ОНТ 80.0 | Тухайн жилд суурилуулсан төхөөрөмжийн тоо | 2 | 2 | Хүн амын унд ахуйн усны эх үүсвэр дээр дүн шинжилгээнд нийцсэн ундны ус, эрүүл ахуйн шаардлага, чанар аюулгүй байдлын стандартыг хангасан тус бүр 2 тн нөөцийн савтай ус цэвэршүүлэх төхөөрөмжийг Говь-Угтаал, Хулд, Эрдэнэдалай сумдад тус бүр 1, Адаацаг суманд 2, | 100 |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | нийт 4 сумын 5 ундны усны эх үүсвэр дээр суурилуулав. Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалт 80.0 сая төгрөг зарцуулсан | |
| 46 | 8 | Эрдэнэдалай суманд ундны усны хайгуул судалгаа хийж, нөөц тогтоох ажлыг гүйцэтгэх | - | Тогтоосон эсэх | - | 1 | Улсын төсвөөр хийлгүүлэх саналтай сайдын гэрээнд санал хүргүүлсэн боловч төсөв нь батлагдаагүй тул хэрэгжээгүй. | - |
| | Нийт арга хэмжээ – 46, (100 хувь - 38, 80 хувь - 1, 55,8 хувь -1, 30 хувь-1) | | | | | | | 96.7 |

БАТАЛГААЖУУЛСАН:

АЙМГИЙН ЗАСАГ ДАРГА Ц.МӨНХБАТ

БИЕЛЭЛТ ГАРГАСАН:

БАЙГАЛЬ ОРЧИН, АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ГАЗРЫН

ДАРГА Н.ГАНТУЛГА

ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭ ХИЙСЭН:

ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ ХЭЛТСИЙН

АХЛАХ МЭРГЭЖИЛТЭН Э.ОДОНЧИМЭГ

Дундговь аймгийн Засаг даргын 2023 оны
11 дугаар сарын 09 өдрийн 01/1547 тоот
албан бичгийн 2 дугаар хавсралт

## 1.2. МЭДЭЭ МЭДЭЭЛЭЛ, СУРГАЛТ СУРТАЛЧИЛГАА

Байгаль орчны тэмдэглэлт өдрүүд















| One Planet | FULL EPISODE | Netflix











lanet | FULL EPISODE | Netflix


Mandalgobi
2023.03.25
60


60+
эх дэлхийн
цаг
03 дугаар сарын 25
20:30-21:30
ЧАГДАРЖАВЫН ТАЛБАЙД УУЛЗАЦГААЯ
1 цагийн турш гэрлээ
унтрааж эх дэлхийгээ
амраая






MAGIC HOSE


"ДУНДГОВИО НОГООРУУЛЪЯ"
ҮЗЭСГЭЛЭН ХУДАЛДАА




















Намрын мод тарих өдрүүд
which will emerge unscathed with their droppings.


Дундговь аймгийн Байгаль орчин, аялал жуулчлалын газар
July 31
Өнөөдөр буюу 07 дугаар сарын 31 "Дэлхийн байгаль хамгаалагчдын өдөр". Монгол орны өнцөг булан бүрт ажиллаж байгаа байгаль хамгаалагчдад "Дэлхийн байгаль хамгаалагчдын өдөр"-ийн мэндийг хүргэе.
"Дэлхийн байгаль хамгаалагчдын өдөр"-ийг жил бүрийн 7-р сарын 31-ний өдөр дэлхий нийтээр тэмдэглэн өнгөрүүлдэг билээ. Дундговь аймгийн хувьд улс, орон нутгийн тусгай хамгаалалттай газарт 11 байгаль хамгаалагч ажиллаж байна.
Энэ өдрийг тохиолдуулан "Цагаан суварга, Дэл уул, Хөнжилийн ... See more
WE STAND WITH THE WORLD'S RANGERS
Ор

1.3. Мэдээллийн санд баяжилт хийв



1.4. И-Монголиа



## 2.1 Эко жорлон арга хэмжээ







Сайнцагаан сумын Шатахуун түгээх станцуудын ариун цэврийн байгууламж, хогийн савны судалгаа

2023 10 30

| № | ШТС нэр | Байршил хаяг | БОАЖГ-ын 2023.10.26-ны өдрийн 202 дугаарт албан бичиг хүлээж авсан тухай тэмдэглэл | /MNS 4943:2011 5924:2015/Стандартын Шаардлага хангасан ариун цэврийн байгууламжтай эсэх | | Шаардлага хангаагүй ариун цэврийн байгууламжтай эсэх /нүхэн жорлон/ | | АЗДаргын А/249 захирамж Ариун цэврийн өрөөгөөр иргэд жуулчид чөлөөтэй үйлчлүүлэх боломжтой эсэх | Ангилан ялгах хогийн савтай эсэх | Холбоо барих |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | Тийм/үгүй | тоо | Тийм/үгүй | тоо | | | |
| 1 | [illegible] | [illegible] | [illegible] | үгүй | [illegible] | тийм | 1 | тийм | үгүй | |
| 2 | [illegible] | [illegible] | [illegible] | [illegible] | [illegible] | үгүй | | [illegible] | үгүй | [illegible] |
| 3 | [illegible] | [illegible] | [illegible] | [illegible] | [illegible] | үгүй | [illegible] | [illegible] | үгүй | [illegible] |
| 4 | [illegible] | [illegible] | [illegible] | [illegible] | [illegible] | [illegible] | 0 | [illegible] | [illegible] | [illegible] |
| 5 | [illegible] | [illegible] | [illegible] | [illegible] | [illegible] | [illegible] | [illegible] | [illegible] | [illegible] | [illegible] |
| 6 | [illegible] | [illegible] | [illegible] | [illegible] | 1 | [illegible] | 0 | [illegible] | [illegible] | [illegible] |
| 7 | [illegible] | [illegible] | [illegible] | [illegible] | 1 | үгүй | 0 | [illegible] | үгүй | [illegible] |

ДУНДГОВЬ АЙМГИЙН БАЙГАЛЬ ОРЧИН, АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ГАЗАР

2023.05.17 № 102

тануй ...-ны № ...

АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ҮЙЛ АЖИЛЛАГАА ЭРХЛЭГЧ АЖ АХУЙН НЭГЖИЙН ДАРГА, ЗАХИРАЛ, ГЭР БУУДЛЫН ЭРХЛЭГЧ НАРТ

Чиглэл хүргүүлэх тухай

Монгол улсын Засгийн газрын 2022 оны 07 сарын 05-ны өдрийн 264 дүгээр тогтоолоор 2023-2024 оныг "Монголд зочлох жил" болгон зарласантай холбогдуулан Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын 2023 оны 02 сарын 28-ны өдрийн "Эрүүл аюулгүй-Цэвэр орчин" бүрдүүлэх 02 дугаар албан даалгавар гарсан.

Албан даалгаврыг хэрэгжүүлэх ажлын хүрээнд аймгийн нэгдсэн төлөвлөгөө батлагдсан бөгөөд албан даалгавар, аймгийн нэгдсэн төлөвлөгөө, Засаг даргын захирамж, Газрын даргын баталсан удирдамж, судалгаа гаргах хүснэгт зэргийг хавсралтаар хүргүүлж байна. Албан даалгавар, төлөвлөгөөний хэрэгжилтийг хангаж аялал жуулчлалын бүс нутаг дахь газруудад их цэвэрлэгээ хийх, цаашид тогтмол хугацаанд зохион байгуулж, нүхэн жорлонг буулгасан, стандартын шаардлага хангасан ариун цэврийн байгууламжтай болсон эсэх, хог хаягдлын менежментийн тухай мэдээллийг нэгтгэн үйл ажиллагааны тайланг сар бүрийн 20-ны дотор мэргэжилтэн А.Ганцэцэгийн a.gantsetseg4305004@gmail.com хаягаар (86911900) ирүүлнэ үү.

Дундговь аймгийн Байгаль орчин, аялал жуулчлалын газар
Газар
Дарга







2.2 Эко сургууль, цэцэрлэг хөтөлбөр









3.2 Зэрлэг амьтдад зориулж, биотехникийн арга хэмжээ авав.











3.4. Дүйцүүлэн хамгааллын арга хэмжээ хэрэгжүүлэв.









3.5 Хог хаягдлаа ангилан ялгаж байна.








**Дундговь аймгийн дахивар цуглуулах цэгийн судалгаа**

| № | Сумын нэр | Дахивар авах цэгтэй эсэх | Дахивар авах цэгийн нэр | Байршил | Үйл ажиллагаа эхэлсэн огноо | 2021 Цуглуулж тушаасан дахиврын хэмжээ /тн/ | 2022 Цуглуулж тушаасан дахиврын хэмжээ | 2023 Цуглуулж тушаасан дахиврын хэмжээ | Нэр | Утас |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| 1 | Адаацаг | тийм | | Хонгорын 6-05 | 2023.7 сараас | 0 | 0 | 0.5тн | Идэрменх | 99806515 |
| 2 | Говь Угтаал | тийм | Говийн наран | Ерлогийн 7-718 | 2017 | 8 | 25 | 30 | Сонинбаяр | 80400082 |
| 3 | Дэлгэрцогт | тийм | Ч.Доржпүрэв шил | Цагаандэл 9-900 | 2020 | 40.000ш шил. | 60000 ш шил | шил 35.000ш. архины 110.000 шил | Ч.Доржпүрэв | 89774040 |
| 4 | Дэрэн | тийм | | Цантын 8-2 | 2023.07 сар | 0 | 0 | 0.3 | Доржсамбуу | 80983161 |
| 5 | Сайнцагаан | тийм | Баялаг төв | Говь зочид буудлын зүүн талын хашаа. Алтан говь зочид буудлын аж ахуйн хашаа 2 агуулах дээр үйл ажиллагаа явуулж байна | 2020.05 | 3тн | 20тн | 45тн | Э.Өлзийбадрах Э.Эрдэнэжаргал | 99980021 99980020 88018075 |
| 6 | Сайхан Овоо | тийм | Онги харгана бүл | Сайхан-Овоо сумын төв | 2023.04.01 | 0 | 0 | 3.5 | Н.Оргилсайхан | 89954222 |
| 7 | Эрдэнэдалай | тийм | | 7-р баг Хогийн зоо | 2023. 07 сараас | | | | С.Хатанбаатар | 99076527 |

3.6 Хогийн цэгийн талбайг шууж, булшилж, тохижуулж байна.



**Дундговь аймгийн Өлзийт сум**

Нэгж талбарын дугаар: 4804000293 Эрхийн төрөл: эзэмших

Регистрийн дугаар: 9033076 Хуулийн этгээдийн нэр: Дундговь аймгийн Өлзийт сумын засаг даргын тамгын газар Тамгын газрын дарга: Б.Оюунханд

ХАЯГ: Аймаг/Хот: Дундговь Сум/Дүүрэг: Өлзийт Баг/Хороо: 4-р баг, Дэрт 1 Кадастрын муж: 0040

ШИНЭ: Гудамж: Аршаант худаг Тоот: 1 ХУУЧИН: ГудамжСумын баруун урд Тоот: Хог цэг

Орчны тойм

WGS84/UTM 48N

EPSG: 32648

Масштаб = 1:27084

Нэгж талбар

| № | X | Y | Урт |
|---|---|---|---|
| 1 | 603787.93 | 4976045.94 | 487.05 |
| 2 | 603882.17 | 4976522.88 | 108.06 |
| 3 | 603990.32 | 4976526.68 | 490.42 |
| 4 | 603914.37 | 4976043.10 | 126.30 |

Барилга

| № | X | Y | Урт | Дугаар | Талбай |
|---|---|---|---|---|---|

Талбайн хэмжээ: 56292 квадрат метр

Зургийн масштаб = 1:3471 (1 сантиметрт 34.71 метр багтана) Хэвлэсэн огноо: 2023-10-04









3.8 Техникийн нөхөн сэргээлт хийгдэв.




3.9 БОАЖЯамны ерөнхий ажлын хэсгийн хурал, сургалтад хамрагдав.



4.1 Булгийн эхийг хашиж хамгаалав.





4.2 Усны сан бүхий газарт тэмдэг, тэмдэглэгээ байршуулав.





4.4 Хөв цөөрөм байгуулав.





4.5 Ус бохирдуулагчийн тооллого зохион байгуулав.





6.2 Улиас, сухайн мөчир бэлтгэж тарилт хийв.





6.3 Иргэд, аж ахуйн нэгж байгууллагад тарьц, суулгац нийлүүлэв





7.2 Ай Ти Эм олон улсын аялал жуулчлалын үзэсгэлэнд оролцов







7.2 Аялал жуулчлалын сургалт, өдөрлөг зохион байгуулав











7.3 Байгаль, түүх, соёлын аялал жуулчлалын эвент зохион байгуулав






GOBI
CARAVANSERAI
СЭТГЭШГҮЙ
ОДДЫН
ЧУУЛГАН
2023
JUNE | 23 | 24 | 25
GOBI CARAVANSERAI DUNDGOBI







## 7.4 Отоглох цэгийн ашиглалт хамгаалалтын менежментийг хийв.





## 8.1 Чип багц төсөл хэрэгжиж байна.







9.5 тарвага нутагшуулах ажлыг зохион байгуулав.





9.7 Цэвэршүүлэх төхөөрөмжийг ус хангамжийн эх үүсвэрт суурилуулав.





Дундговь аймгийн байгаль орчин, аялал
жуулчлалын салбарт хамтран ажиллах
24-10 тоот гэрээний хавсралт

ДУНДГОВЬ АЙМГИЙН БАЙГАЛЬ ОРЧИН, АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН САЛБАРТ 2024 ОНД ХЭРЭГЖҮҮЛЭХ АРГА ХЭМЖЭЭ

| № | | Хэрэгжүүлэх арга хэмжээ | Хүрэх түвшин | Суурь түвшин | Шалгуур үзүүлэлт | Хугацаа | Зардал |
|---|---|---|---|---|---|---|---|
| **1.Байгаль орчны холбогдох хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангах** | | | | | | | |
| 1 | 1 | Байгаль орчны эсрэг гэмт хэрэг зөрчлийг бууруулах зорилгоор хамтарсан хяналт шалгалт зохион байгуулах | 35 | 30 | Хяналт шалгалт хийсэн тоогоор | I – IV улирал | 4.0 ОНТ |
| 2 | 2 | Байгаль орчны салбарын хууль тогтоомжоор сургалт, сурталчилгаа зохион байгуулах | 2500 | 2000 | Хамрагдсан иргэдийн тоо | I – IV улирал | 10.0 БХНСАХЗ |
| 3 | 3 | Мэдээллийн санд баяжилт хийх (eic.mn) | 100 | 100 | маягтын дагуу мэдээлэл бүрэн оруулсан хувь | I – II улирал | - |
| 4 | 4 | Иргэн, аж ахуйн нэгж байгууллагад цахим үйлчилгээ үзүүлсэн тоо | 15 | 10 | Үйлчилгээ үзүүлсэн тоо | I – IV улирал | - |
| 5 | 5 | Байгалийн нөөцийн хамтын менежментийн нөхөрлөлийг дэмжих | 1 | 1 | Дэмжлэг үзүүлсэн тоо | I – IV улирал | - |
| 6 | 6 | "Иргэн бүр байгаль хамгаалагч" уриан дор байгаль орчныг хамгаалах, зөв дадал зуршил бий болгох зорилгоор идэвхтэн байгаль хамгаалагчийг нэмэгдүүлэх | 30 | 22 | Идэвхтэн байгаль хамгаалагчийг нэмэгдүүлсэн тоо (өссөн дүнгээр) | I – IV улирал | - |
| 7 | 7 | 2025 оны байгалийн нөөц ашигласны төлбөрийн орлогын хувь хэмжээ, орлогоос зарцуулах арга хэмжээний төлөвлөлтийг Байгаль орчны төсөв зардлын мэдээллийн санд журамд заагдсан хугацаанд тогтмол оруулах (www.eic.mn) | 100 | 100 | Мэдээллийн сан бүрдүүлсэн хувь | III, IV улирал | - |
| **2. Ногоон хөгжлийн бодлогыг хэрэгжүүлэх** | | | | | | | |
| 8 | 1 | Гэр хороолол, үйлдвэрлэл үйлчилгээний /уул уурхай, аялал жуулчлал, ШТС / бүс дэх | 130 | 109 | Сайжруулсан ариун цэврийн байгууламж, | III, IV-р улиралд | 52.50 Хувийн хэвшил |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | сайжруулсан ариун цэврийн байгууламж, эко жорлонгийн тоог нэмэгдүүлэх | | | эко жорлонгийн тоо (өссөн дүнгээр) | | |
| 9 | 2 | Тогтвортой хөгжлийн боловсрол үндэсний хөтөлбөрийн хэрэгжилтийг хангаж, эко сургууль, цэцэрлэгийн тоог нэмэгдүүлэх | 6 | 5 | Хөтөлбөрт хамрагдаж буй боловсролын байгууллагын тоогоор | I – IV улирал | - |
| 10 | 3 | Эко клубуудын чуулган зохион байгуулах | 100 | - | Оролцогчдын тоогоор | I-II улиралд | - |
| | **3. Хүрээлэн буй орчин, байгалийн нөөцийг хамгаалах** | | | | | | |
| 11 | 1 | Агаарын чанарыг сайжруулах бүсэд мөрдөх журмыг хэрэгжүүлэх | 90 | 90 | Хэрэгжилтийн хувь | I – IV улирал | - |
| 12 | 2 | Мал, амьтны гоц халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх хяналт шалгалт зохион байгуулах | 4 | 2 | Хяналт шалгалтын тоо | I – IV улирал | - |
| 13 | 3 | Зэрлэг амьтдад зориулж, биотехникийн арга хэмжээ авах | 40 | 30 | Биотехникийн арга хэмжээний тоо | I, IV улирал | 5.0 Хувийн хэвшил |
| 14 | 4 | Ашигт малтмалын ашиглалтын тусгай зөвшөөрөл эзэмшигч аж ахуйн нэгж бүрийн 2023 оны Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний биологийн олон янз байдлыг дүйцүүлэн хамгааллын арга хэмжээг авч хэрэгжүүлэх | 18 | 15 | Дүйцүүлэн хамгааллын арга хэмжээний тоо | I – IV улирал | - |
| 15 | 5 | Хог хаягдлыг эх үүсвэр дээр нь бууруулах, дахин ашиглах, дахин боловсруулах 3R цогц менежментийг хэрэгжүүлж эдийн засгийн эргэлтэд оруулах | 65 | 60 | Хог хаягдлыг эх үүсвэр дээр ангилан ялгасан хэмжээ (тн) | I – IV улирал | - |
| 18 | 8 | Эвдэрч, эзэнгүй орхигдсон талбайд нөхөн сэргээлт хийх | 5 | 5 | Нөхөн сэргээсэн талбайн хэмжээ | I – IV улирал | Хувийн хэвшил |
| 19 | 9 | "Нөхөн сэргээлт-2024" нэгдсэн арга хэмжээний аймгийн дэд ажлын хэсгийн үйл ажиллагааг эрчимжүүлж, дэмжиж ажиллах | 90 | 90 | Төлөвлөгөөний хэрэгжилтийн хувь | I – IV улирал | - |
| **4.Усны нөөцийн ашиглах, хамгаалах** | | | | | | | |
| 20 | 1 | Булгийн эхийг хашиж хамгаалах, тохижуулах ажлыг зохион байгуулах | 66 | 63 | Хашсан булгийн тоо | III – IV улирал | 34.4 БХНСАХЗ |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 21 | 2 | Усны сан бүхий газарт тэмдэгжүүлэлтийн ажил зохион байгуулах | 123 | 98 | Тэмдэгжүүлсэн булгийн тоо | II – IV улирал | 6.0 БХНСАХЗ |
| 22 | 3 | Төв суурин газрын ундны усны чанар стандартыг сайжруулан цэвэршүүлэх төхөөрөмжийг ус хангамжийн 1 эх үүсвэрт суурилуулах | 8 | 5 | Суурилуулсан төхөөрөмжийн тоо | I – IV улирал | 60.0 БХНСАХЗ |
| **5.Тусгай хамгаалалттай газар нутгийг хамгаалах** | | | | | | | |
| 25 | 3 | Улсын тусгай хамгаалалттай газар нутагт зөрчлөөс урьдчилан сэргийлэх хамтарсан хяналт шалгалт хийх | 4 | 4 | Хамтарсан хяналт шалгалтын тоо | I-IV улирал | - |
| 26 | 4 | Улсын тусгай хамгаалалттай газрын хамгаалалтын захиргаатай хамтран тусгай хамгаалалттай газрын орчны бүсэд амьдарч буй иргэдэд Байгаль орчныг хамгаалах чиглэлээр сургалт, сурталчилгааны ажлыг зохион байгуулах | 5 | 4 | Сургалт сурталчилгаа хийсэн тоо | I-IV улирал | - |
| **6.Ойн бодлого, "Тэрбум мод" хөдөлгөөнийг өрнүүлж, зорилтын хэрэгжилтийг хангах** | | | | | | | |
| 27 | 1 | Орон нутгийн хөрсөнд дасан зохицсон тарьц, суулгац бэлтгэх мод үржүүлгийн газар шинээр байгуулах | 1 | 1 | Шинээр байгуулсан мод үржүүлгийн тоо | II, IV улирал | 50.0 ОНТ |
| 28 | 2 | Үржүүлгийн зориулалтаар мод, сөөгний үр, мөчрийн нөөц бүрдүүлэх ажлыг зохион байгуулах | 58 | 55.5 | Бэлтгэсэн үр (КГ) | II – IV улирал | 10.0 ОНТ |
| | | | 20500 | 20300 | Мөчрийн тоо | | |
| 29 | 3 | Мод, сөөг, тарьц, суулгацыг ногоон байгууламжид гаргах | 47300 | 47270 | тарьц, суулгацын тоо | I, III улирал | - |
| 31 | 5 | Ногоон байгууламжийг нэмэгдүүлэхэд иргэн, хувийн хэвшлийг татан оролцуулж, мэргэжил арга зүйн дэмжлэг үзүүлэн хамтарч ажиллах | 335529 | 285529 | Модны тоо (өссөн дүнгээр) | II – IV улирал | 100.0 Хувийн Хэвшил |
| **7. Аялал жуулчлалыг хөгжүүлэх** | | | | | | | |
| 32 | 1 | Ай Ти Эм олон улсын аялал жуулчлалын үзэсгэлэнд нэгдсэн байдлаар зохион байгуулах | 10 | 8 | Оролцсон аж ахуйн нэгжийн тоо | III улирал | 5.0 ОНТ, |
| 33 | 2 | Аялал жуулчлал, зочлох үйлчилгээний сургалтад салбарын ажилчдыг хамруулах | 80 | 56 | Хамрагдсан ажилчдын тоо | I-IV улирал | 10.0 ОНТ |
| 34 | 3 | Байгаль, түүх, соёлын аялал жуулчлалын (Тэмээчний өв соёлын баяр, Адуучны өв | 3 | 3 | Зохион байгуулсан арга хэмжээний тоо | I – IV улирал | 30.0 ОНТ |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | соёлын баяр, Сэтгэшгүй оддын чуулган) эвент арга хэмжээг зохион байгуулах | | | | | |
| 35 | 4 | Аялал жуулчлалын гол маршрутын дагуу боловсон ариун цэврийн байгууламж байгуулах. | 1 | - | Ариун цэврийн байгууламжийн тоо | II, III улирал | 20.0 ОНТ |
| **8. Уур амьсгалын өөрчлөлтийг сааруулах, дасан зохицох үйл ажиллагаа** | | | | | | | |
| 36 | 1 | 2022 онд Чип багц суурилуулах гэрээ байгуулсан өрхүүдэд багцыг тараан хэрэглээнд нэвтрүүлэх | 100 | 64 | Хэрэглээнд нэвтрүүлсэн өрхийн тоо (өссөн тоо) | I – IV улирал | 120.0 ОНТ Төсөл хөтөлбөр Хувийн хэвшил |
| **9. Улсын төсвөөр гүйцэтгүүлэх ажлын санал** | | | | | | | |
| 37 | 1 | “Тэрбум мод үндэсний хөдөлгөөн”-ий хүрээнд цөлжилт, газрын доройтлыг бууруулах зорилгоор ойн зурвас байгуулах | 20 | - | Ойн зурвас байгуулсан талбайн хэмжээ (га) | II, IV улирал | 225.0 УТ |
| 38 | 2 | “Онгийн хийд” байгалийн үзэсгэлэнт газарт ариун цэврийн байгууламж бүхий “Отоглох цэг” байгуулах | 3 | 2 | Отоглох цэгийн тоо | III, IV улирал | 150.0 УТ |
| 39 | 3 | Аймгийн хэмжээний цөлжилтийн судалгааг мэргэжлийн байгууллагаар гүйцэтгүүлэх | 1 | - | Судалгааны тоо | III, IV улирал | 150.0 УТ |
| 40 | 4 | Эрдэнэдалай суманд ундны усны хайгуул судалгаа хийж, нөөц тогтоох ажлыг гүйцэтгэх | 1 | - | Тогтоосон эсэх (га) | II, IV улирал | УТ 300.0 |

---oOo---